



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.06.12

№ 01/4998

танай _____-ны № _____-т


Стратегийн явцын тайлан хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2.14 дэх заалтад “Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайлан, өрийн удирдлагын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг Төсвийн байнгын хороонд жил бүр хэлэлцэнэ” гэж заасны дагуу Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн 2023 оны явцын тайланг боловсруулж, хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Хавсралт: 19 хуудастай

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН



9762002306


“ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2023-2025 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧИГ”-ИЙН 2023 ОНЫ ЯВЦЫН ТАЙЛАН

1.1 УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР

Улсын нийт гадаад өрийн хэмжээ 2023 оны жилийн эцсийн байдлаар 34.6 тэрбум ам.доллартой тэнцэж байгаагаас 23.1 тэрбум ам.долларыг аж ахуй нэгжүүдийн гадаад өр, 7.9 тэрбум ам.долларыг Засгийн газрын гадаад өр, 1.8 тэрбум ам.долларыг Төв банкны өр, үлдсэн 1.7 тэрбум ам.долларыг арилжааны банкуудын өр тус тус эзэлж байна.

Улсын нийт гадаад өрийн ДНБ-д харьцуулах харьцаа үзүүлэлт 2021 он хүртэл 200 хувиас өндөр байсан бол 2022 оноос эхлэн буурч 2023 оны жилийн эцсийн байдлаар 174 хувьтай тэнцэж байна.

График №1. Улсын нийт гадаад өр, үлдэгдлээр т.б \$ /2018-2023/



1.2 ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 30,773.5 тэрбум төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа 38.6 хувьтай тэнцэж байна. Энэ нь 2019 оны жилийн эцсээс 16.5 хувиар буурсан үзүүлэлт юм.

Хүснэгт № 1. Засгийн газрын өрийн үлдэгдэл, бүтцээр т.б ₮ /2019-2023/

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
1. Засгийн газрын дотоод өр	1,399.6	1,136.6	657.3	1,035.5	234.1
1.1. Үнэт цаас	1,399.6	1,136.6	657.3	1,035.5	234.1
2. Засгийн газрын гадаад өр	20,728.1	24,851.4	24,693.3	29,641.6	30,274.6
2.1. Үнэт цаас	7,927.2	8,354.0	8,175.6	9,359.8	9,371.7
2.2. Зээл	12,800.9	16,497.4	16,517.7	20,281.8	20,902.9
3. Бусад өр төлбөр	2072.0	1,910.6	1,550.4	1,276.4	264.8
3.1. Засгийн газрын өрийн баталгаа	1,076.3	1,060.4	876.5	812.9	29.5
3.2. Концесс ("барих-шилжүүлэх")	995.7	850.2	673.9	463.5	230.9
4. Орон нутгийн зээллэг	-	-	17.2	12.3	4.5
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)	24,199.7	27,898.6	26,918.1	31,965.8	30,773.5
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)	20,525.6	23,024.3	21,837.3	27,691.6	26,582.9
<i>Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон өрийн хязгаар</i>	75%	70%	70%	70%	65%
<i>Засгийн газрын өр (ӨҮЦ)/ДНБ</i>	55.1%	62.3%	50.8%	52.4%	38.6%

Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын зүгээс Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагын үзүүлэлтийг 2019-2022 онд бүрэн ханган ажилласан бөгөөд Ковид-19 цар тахлын нөхцөл байдалд эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалан арилжааны нөхцөлтэй гадаад, дотоод зээллэгийн үлдэгдэл, Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлийг бууруулан Засгийн газрын гадаад өрийн хэрэгсэл ("бонд" гэх)-ийн дахин санхүүжилтийн арга хэмжээг бодит үр өгөөжтэйгөөр хэрэгжүүлсэн.


Түүнчлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2023 оны төсвийн жилд 65 хувиас хэтрүүлэхгүй байхаар заасан. Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 30.8 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 26.6 их наяд төгрөг буюу ДНБ-ий 38.6 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан өрийн тусгай шаардлагыг **бүрэн хангаж байна.**

1.2.1 Дотоод үнэт цаас

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 234.1 тэрбум төгрөг байна. Үүнээс төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар арилжаалсан үнэт цаасны үлдэгдэл 137.5 тэрбум төгрөг, Сайн хувьцаа хөтөлбөрийг санхүүжүүлэх зориулалттай арилжаалсан үнэт цаасны үлдэгдэл 96.6 тэрбум төгрөг байна.

Стратегийн хэрэгжилтийн хугацаанд Засгийн газрын дотоод үнэт цаасыг арилжаалаагүй бөгөөд арилжаалах шаардлага үүсээгүй байна.

График №2. Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээлэл, т.б ₮ /2016-2023/



Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор 2024 онд Засгийн газрын дотоод үнэт цаасыг Монголын Хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах мөн Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийг дэмжих зорилгоор Тендерийн барьцааны зориулалттай дотоод үнэт цаас гаргах, үүнтэй холбоотой журамд нэмэлт өөрчлөлт оруулах, арилжааны дэд бүтцийг сонгох зэрэг бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Засгийн газрын үнэт цаасны арилжааг Монголбанкаар дамжуулан арилжаалснаар анхдагч зах зээл дэх арилжааны банкнаас бусад оролцогчдын оролцоо хязгаарлагддаг тул шударга өрсөлдөөнт байдлаар үнэт цаасны хүү тогтох боломж дутмаг байдаг сул талуудтай байсан.

Дээрх шалтгаануудын улмаас Засгийн газрын дотоод үнэт цаасны нээлттэй арилжаа 2017 оноос эхлэн зогссон бөгөөд 2022 онд Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор Өрийн удирдлагын тухай хууль, Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журмыг үндэслэн 2022 оны 7 болон 11 саруудад нийт 683.9 тэрбум төгрөгийн үнэт цаасыг дотоодын аж ахуйн нэгжүүдэд гаргасан.

Цаашид Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааг мэргэжлийн хөрөнгө оруулагч, иргэд, аж ахуй нэгжийн оролцоог бүрэн хангах байдлаар нээх, үнэт цаасны оролцогчдын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх олон нийтэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн

ажиллаж байна. Ингэснээр хөрөнгө оруулагчдын бааз суурь нэмэгдэж, Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжаанд оролцогчдын эрэлтийг нэмэгдүүлэх, хоёрдогч зах зээл дэх үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах давуу талуудтай болно.

1.2.2 Гадаад үнэт цаас

Засгийн газраас олон улсын зах зээлд арилжаалсан гадаад үнэт цаасны үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 9,371.7 тэрбум төгрөг буюу 2,747.8 сая ам.доллартой тэнцэж байна.

Хүснэгт № 2. Гадаад үнэт цаасны мэдээлэл, т.б ₮ /2023.12.31/

№	Гадаад үнэт цаас	Гаргасан хэмжээ /сая \$/	Гаргасан огноо	Хүү	Хугацаа	Үлдэгдэл /тэрбум ₮/
1	Хуралдай	600.0	2017/03	8.750%	7 жил	579.0
2	Номад	600.0	2020/09	5.125%	5.5 жил	1,971.4
3	Сенчири-2027	500.0	2021/06	3.500%	6 жил	1,705.4
4	Сенчири-2031	500.0	2021/06	4.450%	10 жил	1,705.4
5	Сенчири-2	650.0	2023/01	8.650%	5.5 жил	2,216.9
6	Сенчири-3	350.0	2023/12	7.875%	5 жил	1,193.6
НИЙТ						9,371.7

Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх ачааллыг жигдлэх, өрийн үйлчилгээний зардлыг бууруулах зорилгоор 2023 онд 21.4 сая ам.доллар буюу нийт 73.8 тэрбум төгрөгтэй тэнцэх Гэрэгэ бондын үлдэгдлээс зах зээлийн тохиромжтой цаг үеийг ашиглан эргэн төлөгдөх үнээс хямд өртөгтэйгөөр хоёрдогч зах зээл дээрээс буцаан худалдан худалдан авах өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Дээрх нээлттэй зах зээл дээрээс буцаан худалдан авах өрийн зохицуулалтын үр дүнд Засгийн газрын өрийн үйлчилгээний зардлаас нийт 1.9 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийн хэмнэлтийг улсын төсөвт үүсгэсэн.

Харин 2023 онд Засгийн газрын зүгээс олон улсын санхүүгийн зах зээлийн нөхцөл байдлыг анхааралтай ажиглаж, олон улсын хөрөнгө оруулагчидтай тогтмол мэдээлэл солилцож, эдийн засгийн үзүүлэлтүүд 2022 оны гүйцэтгэлээр сайжирч, зах зээлийн цонх үеийг ашиглан 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр “Сенчири 2” төслийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар 5 жилийн хугацаатай, 8.65 хувийн хүүтэй, нийт 650 сая ам.долларын өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж хугацаа тулаад байсан “Гэрэгэ” бондоос 149.3 сая ам.доллар, “Хуралдай” бондоос 495.3 сая ам.доллартой тэнцэх хэсгийг дахин санхүүжүүлээд байна.

Түүнчлэн, 2023 оны 11 сард 350 сая ам.долларын хэмжээтэй, 5.5 жилийн хугацаатай 7.875 хувийн хүүгийн түвшинтэйгээр “Сенчири-3” бондыг гаргаж Хуралдай бондын дийлэнх хэсгийг дахин санхүүжүүлснээр үлдэгдэл 169.7 сая ам.доллар болсон.

1.2.3 Гадаад зээл

Монгол Улсын Засгийн газрын зүгээс 1991 оноос 2023 оны хооронд нийт 8,706.3 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн хөрөнгийг 22 зээлдүүлэгчээс 340 төсөл хөтөлбөрт зарцуулсан байдаг. Үүнээс 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр нийтдээ 2,163.9 сая ам.долларыг эргэн төлж 6,128.5 сая ам.доллартой тэнцэх үлдэгдэлтэй буюу 20,902.9 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Хүснэгт № 3. Гадаад зээлийн үлдэгдэл, т.б ₮ /2019-2023/

Төрөл	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Хөтөлбөрийн зээл	3,691.5	5,560.3	5,450.7	6,551.9	6,719.4
Төслийн зээл	9,109.3	10,937.0	11,066.9	13,729.9	14,183.5
НИЙТ	12,800.8	16,497.4	16,517.6	20,281.8	20,902.9

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл бодитоор жил бүр өсөж байгаа бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар ашиглаагүй үлдэгдэл 3.0 тэрбум ам.доллар буюу 10.4 их наяд төгрөгтэй тэнцэж байна. Үүнээс жил бүр Улсын төсөвт төсөвлөхдөө нийт гадаад зээлийн ашиглалтын хэмжээг 1.3 их наяд төгрөгөөс ихгүй байхаар хязгаарладаг тул үлдэж буй ашиглаагүй зээлийн хэмжээнд тодорхой хувиар шимтгэл төлөх нөхцөлтэй зээлд төлж байгаа төлбөрийн хэмжээ сүүлийн 5 жилийн дунджаар 14.2 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Цаашид Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 стратегийн баримт бичгийн хүрээнд Засгийн газар хөгжлийн түншүүдтэй хөгжлийн хамтын ажиллагааны дунд хугацааны стратегийг тохиролцон Засгийн газрын шугамаар гадаад улс, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас зээл авахдаа зээлийн ерөнхий хэлэлцээр байгуулагдсан, тусгайлсан зээлийн хэлэлцээрээр эх үүсвэр баталгаажсан, эдийн засгийн үр ашигтай төсөл, арга хэмжээ байх шаардлагыг тавьж, үргэлжилж буй төслүүдийн хувьд тухайн жилд дуусгавар болох төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн тусгах, тэргүүлэх ач холбогдолтой, амжилттай хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг дэмжих зарчмыг баримтлан ажиллана.

1.2.4 Засгийн газрын өрийн баталгаа

Өрийн удирдлагын тухай хууль 2015 оны 02 дугаар сард батлагдсанаар Засгийн газрын өрийн баталгаа гаргахад баталгаа гаргуулагч болон төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага хуульчлагдаж, өрийн баталгаа гаргуулах хүсэлтэд эрсдэлийн үнэлгээ хийх, төсөл, арга хэмжээнд хяналт тавих зэрэг хууль эрх зүйн орчин бүрдсэн. Тус хууль батлагдахаас өмнө Засгийн газрын зүгээс Монгол Улсын Хөгжлийн банкны дунд хугацааны евро бонд, Самурай бонд, Кредит Свисс банкнаас авсан зээл, БНХАУ-ын Хөгжлийн банкнаас авсан зээл, "МИАТ" ТӨХК-ийн агаарын

хөлгийн санхүүжилт зэрэг нийтдээ 2.7 их наяд төгрөгтэй тэнцэх зээллэгүүдэд баталгааг гаргасан байдаг.

Өрийн удирдлагын тухай хууль батлагдсанаас хойш Худалдаа хөгжлийн банкны олон улсын зах зээлд арилжаалсан үнэт цаас, “Эрдэнэс Монгол” ХК-ийн Азийн хөгжлийн банкнаас авсан зээлүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан.

Засгийн газрын баталгааны үлдэгдэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 1,060.4 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан бол Монгол Улсын Хөгжлийн банкны зүгээс Засгийн газартай хамтран өрийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж өөрийн эх үүсвэрээс хугацаа тулаад байсан “Евробонд” болон Засгийн газрын өрийн баталгаатай “Самурай” бондуудыг амжилттай төлж барагдуулснаар Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр буурч, 2023 оны жилийн эцсийн байдлаар 29.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Хүснэгт № 4. Засгийн газрын баталгааны үлдэгдэл, т.б ₮ /2023.12.31/

№	Баталгаа гаргуулагч	Зээлдүүлэгч	Валют	2023.12.31	
				Үндсэн валют /сая/	Тэрбум төгрөг
1	Эрдэнэс Монгол ХК	Азийн Хөгжлийн Банк	Ам.доллар	9.1	29.5
НИЙТ					29.5


“Эрдэнэс Монгол” ХК-ийн техникийн туслалцааны зээлийг 2031 онд төлөгдөж дуусна.

1.2.5 “Барих-шилжүүлэх” төрлийн концесс

Улсын төсвөөс 2014-2017 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй 2.3 их наяд төгрөгтэй тэнцэх 40 концессын гэрээ болон орон нутгийн төсвөөс 2013-2016 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй 133.4 тэрбум төгрөгтэй тэнцэх 50 концессын гэрээ тус тус байгуулагдсан байна. “Барих-шилжүүлэх” төрлийн концессын гэрээ байгуулагдсан дүнгээр Засгийн газрын өрийн хэмжээг нэмэгдэж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг өсгөж, ирэх онуудын төсөвт ирэх төлбөрийн дарамт эрс нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 37 дугаар тогтоолоор барих-шилжүүлэх концессын гэрээг дахиж байгуулахгүй байх, гэрээ нь хүчин төгөлдөр болоогүй төсөл, арга хэмжээг зогсоох шийдвэр гарсан.

Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэгт улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээ нь өрийн хэрэгсэлд тооцогдохоор хуульчлагдсан бөгөөд мөн хуулийн 40.7 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, концессын гэрээний дагуу улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэж Засгийн газрын өрд бүртгэнэ” гэж заасан. Сангийн яамны зүгээс Эдийн засаг, хөгжлийн яам болон орон нутгийн захиргааны байгууллагуудаас улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан концессын ашиглалт, гүйцэтгэлийн мэдээллийг улирал бүр авч Засгийн газрын өрд бүртгэж байна. Харин Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор Өрийн удирдлагын хуулийн дээрх заалт хүчингүй болсон тул 2024 оноос эхлэн барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдлийг Засгийн газрын өрийн үлдэгдэлд оруулж тайлагнахгүй байхаар зохицуулагдсан.

График № 3. Барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдэл, т.б ₮ /2023.12.31/



Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх концессын үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн байдлаар 230.9 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

2. ЗАСГИЙН ГАЗРЫН ЗЭЭЛЛЭГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Засгийн газрын 2023 оны зээллэгийн төлөвлөгөөний хүрээнд Засгийн газрын дотоод үнэт цаасны гаргалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт № 7. Засгийн газрын дотоод үнэт цаасны 2023 оны арилжааны төлөвлөгөө гүйцэтгэл

№	Зээлдүүлэгч	Зориулалт	Төлөвлөгөө Сая ₮	Гүйцэтгэл	Тайлбар
1	Дотоод үнэт цаас	Төсвийн алдагдал санхүүжүүлэх	650,579.8	0.0	2023 онд Төсвийн гүйцэтгэлээр төсөв ашигтай гарсан тул нэмэлтээр дотоод үнэт цаас гаргаж өрийн зардлын нэмэгдүүлээгүй болно.
2		Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжих	161,391.9	0.0	
3		Өрийг дахин санхүүжүүлэх	801,360.0	0.0	
4	Гадаад үнэт цаас	Өрийг дахин санхүүжүүлэх	4,025,000.0	3,457,017.3	2023 онд Сенчири-2, Сенчири-3 бондуудыг гаргасан
5	Гадаад зээл	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх	1,224,500.0	1,214,119.4	Нийт 11 зээлдүүлэгчийн 71 төслийн хүрээнд авч ашигласан
6	Гадаад зээл	Хөтөлбөрийн зээл	700,000.0	692,535.0	2 удаагийн хөтөлбөрийн зээлийг авч ашигласан.
7	Засгийн газрын өрийн баталгаа	Засгийн газрын өрийн баталгаа гаргах	3,730,335.0	0.0	Засгийн газрын өрийн баталгаа гаргах хүсэлт ирүүлээгүй болно.
Нийт			7,562,831.7	5,363,671.7	

Засгийн газраас 2023 онд өрийг дахин санхүүжүүлэх зорилгоор 4,025,000.0 сая төгрөгтэй тэнцэх гадаад үнэт цаасыг арилжихаар төлөвлөснөөс нийт 3,457,017.3 сая төгрөгтэй тэнцэх үнэт цаасыг гаргасан. Тухайлбал, 2023 оны 01-р сард 650.0 сая ам.долларын 8.65 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай Сенчири-2 бондыг мөн 2023 оны 12 дүгээр сард 350.0 сая ам.долларын 7.875 хувийн хүүтэй, 5.5 жилийн хугацаатай Сенчири-3 бондыг тус тус гаргасан.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд 2023 онд нийт 1,224.5 тэрбум төгрөгтэй тэнцэх эх үүсвэрийг ашиглахаар төлөвлөснөөс нийт 11 зээлдүүлэгчээс 1,214.1 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний эх үүсвэрийг авч ашигласан байна.

3. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАГЦЫН ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТОТ БҮТЭЦ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

3.1 Засгийн газрын өрийн багцад хийсэн зардал эрсдэлийн шинжилгээний үр дүн

Хүснэгт № 8. Засгийн газрын өрийн багцын гүйцэтгэл болон төсөөлөл

Засгийн газрын өрийн багцын үзүүлэлтүүд	Гүйцэтгэл		Төсөөлөл		
	2023	Түвшин	2023	2024	2025
1. Өрийн зардал					
Жигнэсэн дундаж хүү /хувь/	3.5	Дээд	3.8	4.3	4.8
2. Дахин санхүүжилтийн эрсдэл					
Засгийн газрын өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа /жил/	7.9	Доод	7.8	7.3	6.8
3. Хүүгийн эрсдэл					
Засгийн газрын өрийн ATR /жил/	7.1	Доод	7	6.5	6.3
4. Ханшийн эрсдэл					
Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр* /нийт өрд эзлэх хувь/	98.5	Дээд	80	80	80

3.2 Дунд хугацаанд дэвшүүлж байгаа зорилт, хэрэгжүүлэх арга зам түүний хэрэгжилт

Засгийн газрын зүгээс “Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг”-ийг боловсруулж үндсэн 6 зорилтыг дэвшүүлсэн.

Зорилт 1. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр

хэрэгжих төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, гадаад зээлийн өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулна.

1.1 Эдийн засгийн бодит өсөлт болон экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй, гадаад улс орны худалдан авалтыг дэмжих замаар импортыг өсгөж, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах нөлөө бүхий Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрийг авч ашиглахаас татгалзах;

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг сайжруулах, төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулах арга хэмжээний

хүрээнд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банкттай 2016 онд байгуулсан гадаад зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, эргэн төлөх нөхцөлийг сайжруулахаар Энэтхэгийн талтай 6 сарын турш санал солилцож 2023 оны 8 дугаар сарын 17-ны өдөр “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл”-ийн 1.0 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд дэд гэрээнүүдэд гарын үсэг зурснаар 2023 оноос төлөгдөж эхлэх байсан үндсэн төлбөрийн хэмжээг бууруулж улсын төсөвт учруулж буй ачааллыг багасгасан.

Тухайлбал, дэд зээлийн гэрээнүүдийг байгуулснаар EPC-02, EPC-03 багц ажлын зээлийн эргэн төлөлт болох 789 сая ам.долларын үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацааг дахин 7 жилээр хойшлуулж, 2023 оноос эхлэн зээлийн үндсэн төлбөрт 64.5 сая ам.доллар төлж эхлэх байсныг 13.1 сая ам.доллар болгон бууруулж, төсвийн дарамтыг багасгасан. Мөн хуучин гэрээний нөхцлөөс шалтгаалан 2018 оноос хойш хийгдэхгүй гацаанд ороод байсан EPC-02, EPC-03 багц ажлын санхүүжилт авах боломжийг шинээр тохиролцсон гэрээний нөхцлийн хүрээнд бүрдүүлж өгснөөр төслийн явцыг эрчимжүүлээд байна.

Түүнчлэн, 2023 онд Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн нийт 10 саналыг салбар яамдуудаас ирүүлсэн. Энэхүү саналуудыг судалж Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байх, төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ болон зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг хийж, баталгаажуулсан байх зэрэг бусад холбогдох шаардлагуудыг хангаагүй бөгөөд Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт нийцээгүй импортыг өсгөж болзошгүй төслийн саналуудыг холбогдох яамдуудад албан бичгээр хариу өгч буцаасан. Үүнд, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрчим хүчний яам, Гадаад харилцааны яам болон Хууль, зүй дотоод хэргийн яамнаас ирүүлсэн нийт 7 төслийн саналууд багтсан байна.

1.2 Өрийн удирдлагын тухай хуулийн 7.1.6-д зааснаас бусад тохиолдолд зөвхөн бодит эдийн засгийн салбарт чиглэсэн төслийг санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын гадаад зээл авч ашиглах;

Энэ хүрээнд Засгийн газраас 2023 онд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн урт хугацааны баримт бичигт заасан эдийн засгийн тэргүүлэх чиглэл болох бодит эдийн засгийн салбарт чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, олон улсын түнш байгууллагуудаас нийт 1,939.0 тэрбум төгрөгтэй тэнцэх эх үүсвэрийг авч ашигласан. Тухайлбал, барилга байгууламжийн салбарт 355.9 тэрбум төгрөг, үйлчилгээний салбарт 1,048.3 тэрбум төгрөг, үйлдвэрлэлийн салбарт 482.5 тэрбум төгрөг, хөдөө аж ахуйн салбарт 48.2 тэрбум төгрөгийг тус тус авч ашиглажээ.

Түүнчлэн, 2023 онд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг, Өрийн удирдлагын тухай хууль болон Өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт нийцсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр нийт 12 гадаад зээлийн хэлэлцээрийг санхүүжүүлэгч талтай байгуулсан. Эдгээр төслүүд нь Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт заасан эдийн засгийн тэргүүлэх чиглэл болох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх, эдийн засгийн хөгжлийг дэмжих эрчим хүч, инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, үндэсний тээвэр, логиستيкийн тогтолцоог хөгжүүлэх зэрэг зорилтуудтай нийцсэн байна.

1.3 Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжааны нөхцөлтэй зээллэг хийхгүй байх;

Засгийн газраас 2023 онд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжааны нөхцөлтэй зээллэг авч ашиглаагүй байна.

Зорилт 2. Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна.

2.1 Гадаад зах зээлийн нөхцөл байдал, зардал, эрсдэлийн судалгааг тогтмол хийж, Засгийн газрын гадаад үнэт цаасыг хугацаанаас нь өмнө худалдан авах арга хэмжээг хэрэгжүүлэх

Олон улсын санхүүгийн зах зээлийн судалгаа, Монгол Улсын Засгийн газраас арилжаалсан үнэт цаасны хоёрдогч зах зээл дэх үнэ, өгөөжийн судалгааг олон улсын мэдээний “Bloomberg” платформоос өдөр бүр бэлтгэн гаргаж. Олон улсын зах зээл дээрх тохиромжтой үеийг ашиглан Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдлийн зарим хэсгээс буцаан худалдан авах үйл ажиллагааг 2023 онд амжилттай хэрэгжүүлсэн.

Тухайлбал, Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх ачааллыг жигдлэх, өрийн үйлчилгээний зардлыг бууруулах зорилгоор 2023 онд 22.0 сая ам.доллар буюу нийт 75.7 тэрбум төгрөгтэй тэнцэх Гэрэгэ бондын үлдэгдлээс эргэн төлөгдөх үнээс хямд өртөгтэйгөөр хоёрдогч зах зээл дээрээс буцаан худалдан худалдан авах өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Дээрх нээлттэй зах зээл дээрээс буцаан худалдан авах өрийн зохицуулалтын үр дүнд Засгийн газрын өрийн үйлчилгээний зардлаас нийт 1.9 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийн хэмнэлтийг улсын төсөвт үүсгэсэн.

2.2 Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг мөнгөн хөрөнгийн хуримтлалаас боломжит хэмжээгээр төлөх, өрийн зохицуулалтын арга хэмжээ,

хугацаанаас нь өмнө худалдан авах, дахин санхүүжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд 2023 оны 1 дүгээр сард 650 сая ам.долларын “Сенчири-2” бондыг олон улсын зах зээлд 5 жилийн хугацаатай, 8.65 хувийн хүүтэй арилжаалж “Гэрэгэ” бондын үлдэгдлээс 435.3 сая ам.доллар, “Хуралдай” бондын үлдэгдлээс 207.5 сая ам.долларыг тус тус шийдвэрлэсэн болно. Түүнчлэн, 12 дугаар сард 350.0 сая ам.долларын хэмжээтэй “Сенчири-3” бондыг олон улсын зах зээлд 5.5 жилийн хугацаатай, 7.875 хувийн хүүтэйгээр гаргаж, Хуралдай бондын үлдэгдлээс 339.7 сая ам.долларыг шийдвэрлэсэн.

Түүнчлэн, гадаад үнэт цаасны төлбөрийг мөнгөн хөрөнгийн хуримтлалаас боломжит хэмжээгээр төлөх арга хэмжээний хүрээнд Гэрэгэ бондын үлдэгдэл төлбөр болох 90.8 сая ам.долларыг 2023 оны 04 дүгээр сарын 28 -ны өдөр Төрийн сангийн мөнгөн хөрөнгөнөөс төлж барагдуулсан.

2.3 Дахин санхүүжилтээс бусад зориулалтаар Засгийн газрын гадаад үнэт цаасыг арилжаалахгүй байх;

Засгийн газраас 2023 онд дахин санхүүжилтийн арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Сенчири 2 болон 3 бондуудыг арилжаалсан бөгөөд бусад зориулалтаар гадаад үнэт цаас шинээр гаргаагүй болно.

2.4. Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах үүднээс зэрэглэл тогтоогч байгууллага, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр тогтмол ханган хамтарч ажиллах;

Засгийн газрын зүгээс улсын зээлжих зэрэглэлийг тогтвортой хадгалах, цааш нь сайжруулах зорилгоор гадны томоорон хөрөнгө оруулагчид, зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагууд болох “JP Morgan”, “Black Rock”, “Fitch”, “Moody’s” болон “S & P” -рүү улирал бүр Засгийн газрын өрийн үлдэгдэл, эргэн төлөлт, шинээр үүсгэсэн зээллэг, дунд хугацаан дах гадаад өрийн эргэн төлөлтийн төлөвлөгөө болон Монгол Улсын макро эдийн засгийн нөхцөл байдлын талаарх холбогдох мэдээллээр тогтмол ханган ажилласан.

Түүнчлэн, Монгол Улсын Сангийн яам, Монголбанк болон Монгол Улсын Хөгжлийн банкны баг бүрэлдэхүүн 2023 оны 6 дугаар сарын 4-өөс 15-ны өдрүүдэд Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк хот, Их Британийн Лондон хот болон ХонгКонг, Сингапур улсуудаар нийт 110 гаруй олон улсын хөрөнгө оруулалтын сантай танилцуулга уулзалт зохион байгуулж, олон улсын зах зээлээс хөрөнгө оруулалт татах тохиолдолд хөрөнгө оруулагчдын сонирхлыг тодорхойлох мөн Монгол Улсын

эдийн засгийн сэргэлт, Хөгжлийн банкны санхүүгийн нөхцөл байдлын талаар зэрэг мэдээлэл хүргэж ажилласан.

2023 оны 05 дугаар сард олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Фитч агентлагийн төлөөлөлтэй, 07 дугаар сард Эс энд Пи агентлагийн төлөөлөлтэй тус тус уулзалтыг зохион байгуулж, зээлжих зэрэглэл тогтоолгосон бөгөөд Монгол Улсын 2023 оны зээлжих зэрэглэлийг В тогтвортой түвшинд хэвээр хадгалаад байна. Тус уулзалтын хүрээнд цаашид зээлжих зэрэглэлээ нэмэгдүүлэхэд дараах нөхцөлийг тавьсан болохыг мэдэгдсэн. Үүнд:

- Гадаад валютыг албан нөөцийг их хэмжээгээр нэмэгдүүлж, гадаад санхүүжилтийн хэрэгцээг бууруулж тогтвортой байдлыг хадгалах;
- Макро эдийн засгийн зөв, зохистой бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, түүхий эдийн үнийн болон олон улсын эдийн засгийн савлагаанд хэт мэдрэг байдлыг бууруулж, гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэхэд таатай бизнесийн орчныг бүрдүүлэх;
- Засгийн газрын өрийн ДНБ-тэй харьцах харьцааг тогтмол бууруулах;
- Монгол Улсын эдийн засаг таамаглаж байгаагаас илүү буюу ижил орлоготой улс орнуудтай харьцуулахад сайжрах;
- Эдийн засгийн өсөлт хүлээлтээс давж өссөн тохиолдолд энэ нь төсөв, өр, гадаад зах зээлийн үзүүлэлтийг хурдан сайжруулах;
- Монгол Улсын тогтолцооны шинэчлэл, сайжруулалт хийх, ялангуяа бодлого боловсруулахдаа бодит ахиц дэвшил гаргах зэрэг болно.

Зорилт 3. Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор үүсмэл арга хэрэгслийг өрийн зохицуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

3.1 Засгийн газрын хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр Монголбанктай хамтран ажиллаж, гадаад өрийн үйлчилгээний хуваарийг валютын нөөцтэй уялдуулах, шаардлагатай тохиолдолд валют болон хүүгийн своп хэлэлцээрийг зээлдүүлэгч талтай хийх;

Засгийн газраас 2023 онд Монголбанктай хамтарч Улсын төлбөрийн тэнцлийг дэмжих, Монголбанкны гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 200 сая ам.долларын хөтөлбөрийн зээлийг авч ашигласан бөгөөд гадаад зээллэгийн өрийн үйлчилгээг цаг тухайд тогтмол төлж, Монголбанкнаас шинээр нэвтрүүлсэн RTGX системээр гадаад валютын нөөцтэй уялдуулан гадаад төлбөр тооцоог хийж байна.

Түүнчлэн, Монгол Улсын гадаад валютын нөөцийг ихэсгэх, Засгийн газрын хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн санд хуримтлагдсан Сенчири-

2 бондын 300 сая ам.доллартой тэнцэх хэмжээний ам.долларын эх үүсвэрийг Монголбанкаар дамжуулан Францын төв банкинд 4.75 хувийн хүүтэйгээр 3 сарын хугацаанд хадгалуулж 2.3 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хүүгийн орлогыг олсон.

3.2 Дэлхий нийтэд тулгараад байгаа нь инфляцын өсөлтөөс шалтгаалан гадаад зах зээлд бий болоод байгаа хүүгийн өсөлтөөс хамааран урт, дунд хугацаанд Засгийн газрын гадаад зээлийн хөвөгч хүү өсөх тохиолдолд тогтмол хүүтэй зээл авах нөхцөлийг зээлдүүлэгч талд тавьж ажиллах

2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаар батлагдсан “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн 560.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн хөрөнгийг хөвөгч хүүтэй байхад 420.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийг тогтмол хүүтэй, үлдсэн 140 сая ам.долларыг хөвөгч хүүтэй нөхцөлтэйгөөр авч ашиглах болгож зээлийн нөхцөлийг сайжруулаад байна.

3.3 Өрийн удирдлагын санхүүгийн шинжилгээний нэгдсэн системийг сайжруулж, мэдээллийн нэгдсэн санг шинэчлэх нөхцөлийг бүрдүүлэх;

Өрийн удирдлагын санхүүгийн шинжилгээний системийг (DMFAS) анх 2001 оноос Монгол Улсын Засгийн газраас ашиглаж эхэлсэн. “DMFAS”-ыг ашигласнаар Засгийн газрын өрийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, тайлан мэдээ гаргах болон зардал эрсдэлийн шинжилгээ хийх зэрэг өрийн удирдлагын тогтолцоонд суурь шинэчлэлтийг хийсэн байдаг.

Түүнчлэн, “DMFAS” нь дэлхийн 100 гаруй оронд ашиглагддаг Засгийн газрын өрийн удирдлагын суурь систем боловч Төрийн өмчит байгууллагын гадаад өрийг бүртгэх, мөнгөн урсгалын төсөөлөл хийх зэрэг зарим шаардлагатай функцууд ороогүй тул Засгийн газраас өрийн мэдээллийн санг шинэчлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд Өрийн удирдлагын санхүүгийн шинжилгээний дэд систем болох DMS-ийг шинээр хөгжүүлсэн.

Энэхүү систем нь Төрийн өмчит байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэх, мөнгөн урсгалын төсөөлөл боловсруулах, зардал эрсдэлийн үзүүлэлтүүдийг тооцох зэрэг “DMFAS”-д дутагдаж байсан функцуудыг нэмж оруулж ирснээр өрийн мэдээллийн санг илүү өргөн цар хүрээтэйгээр бүрдүүлэх боломжийг бий болгоод байна.

3.4 Орон нутгийн засаг захиргааны өрийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлээс сэргийлэх, Засгийн газрын өрийн мэдээллийн нэгдсэн санг хөтлөх талаар хамтран ажиллах.

Өрийн удирдлагын тухай хуулийн 28 дүгээр зүйлийн 28.7 дахь хэсэгт “аймаг, нийслэлийн Засаг даргын үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэхтэй холбогдсон

журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулан, Засгийн газарт баталж мөрдүүлнэ” гэж заасны дагуу Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 199 дүгээр “Журам батлах тухай” тогтоолын хавсралтаар “Нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх журам”-ыг баталснаар нийслэлээс дотоодын зах зээлд үнэт цаас гаргах эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн болно.

Энэхүү журмыг Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журмын хүрээнд боловсруулсан. Журмын хүрээнд нийслэлийн үнэт цаас гаргах шаардлага, талуудын чиг үүрэг, арилжааны төлбөр тооцоо болон хяналтын талаар тусган зохицуулж өгсөн. Түүнчлэн, нийслэлийн Засаг дарга дотоод зах зээлд үнэт цаас гаргах асуудлыг нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулж дэмжсэн тохиолдолд санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтэд үндэслэн Сангийн сайд Засгийн газраар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

Түүнчлэн, 2023 онд Нийслэлийн Засаг Даргын тамгын газраас авах Засгийн газрын авлагын эргэн төлөлтийг сайжруулж нийт 81.4 тэрбум төгрөгтэй тэнцэх хугацаа хэтэрсэн төлбөрийг төлүүлж орон нутгийн засаг захиргааны өрийн удирдлагын чадавхыг сайжруулж ажилласан.

Зорилт 4. Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна.

4.1 Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаанд орчин үеийн дэвшилтэт технологийг ашигласан арилжааны систем нэвтрүүлэх:

Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны 14 дүгээр тэмдэглэлд Монголын хөрөнгийн биржээр дамжуулан Засгийн газрын дотоод үнэт цаасыг олон нийтэд нээлттэй арилжаалах талаар танилцуулсан.

Үүнтэй холбоотой Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 77 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам”-д нийцүүлэн Монголын хөрөнгийн бирж ХК-тай хамтран ЗГДҮЦ-ны дэд бүтцийг сайжруулах хүрээнд bond.mse.mn анхдагч арилжааны системийг хөгжүүлээд байна. Уг систем нь ЗГДҮЦ-ны анхдагчийн арилжааг дээрх журамд заасны дагуу нэгдсэн болон ялгавартай үнэтэй явуулахаар хийгдсэн бөгөөд ЗГДҮЦ гаргах арилжааны мэдэгдэл, үр дүнгийн талаарх мэдээллийг авах боломжтой болно. Түүнчлэн, хадгаламж, төлбөр тооцоо гүйцэтгэгч болох “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”-тэй систем нь холбогдож ЗГДҮЦ гаргах бэлтгэл ажлыг хангаад байна.

4.2 Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгийн зах зээл дэх жишиг хүүгийн түвшнийг тогтоох зорилгоор жил бүр шинээр гаргах Засгийн газрын дотоод үнэт цаасны 10-20 хүртэлх хувийг урьдчилан зарласан хугацаа,

нөхцөл бүхий хуваарийн дагуу арилжаа зохион байгуулагдахаас 3 сарын өмнө олон нийтэд нээлттэй зарлаж, хуваарийн дагуу үнэт цаасны арилжааг зохион байгуулах замаар арилжааг тогтмолжуулах.

Стратегийн хэрэгжилтийн хугацаанд дотоод үнэт цаасны нээлттэй арилжааг хийгээгүй бөгөөд Засгийн газраас төсвийн дарамтыг бууруулах, төсвийн зарлагыг хязгаарлах бодлогыг баримталж 2023 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлээр улсын төсөв 763.0 тэрбум төгрөгийн ашигтай гарсан тул Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаалах шаардлага үүсээгүй болно.

Зорилт 5. Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангаж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг хязгаарлана.

5.1 Эдийн засаг болон нийгмийн үр өгөөж өндөртэй төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан. "Шинэ сэргэлтийн бодлого"-д нийцсэн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрт Засгийн газрын өрийн баталгаа гаргах замаар дэмжлэг үзүүлэх;

"Шинэ сэргэлтийн бодлого"-д туссан стратегийн чухал ач холбогдол бүхий төсөл болох "Чойбалсан Дулааны Цахилгаан Станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар нэмэгдүүлж, өргөтгөх төсөл"-ийн санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор Улсын Их Хурлын 2023 оны 90 дүгээр тогтоолоор тус төслийн хүрээнд 2024 онд Засгийн газрын өрийн баталгаа гаргахаар шийдвэрлэсэн. Уг төсөл амжилттай хэрэгжсэнээр Дорнод, Сүхбаатар аймгийн 36 сум, багийн 25,139 айл өрх, 3,133 аж ахуйн нэгж, албан байгууллага, уул уурхайн 13 ордын олборлох үйлдвэрүүд тасралтгүй, найдвартай эрчим хүчээр хангагдаж, БНХАУ-аас импортоор авдаг эрчим хүчний хэмжээг жилд 438 сая кВт.цагаар бууруулах ач холбогдолтой юм.

5.2 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гаргах Засгийн газрын өрийн баталгаанаас төсөвт үүсэж болзошгүй эрсдэлийг үнэлэх, эрсдэлээс сэргийлэх чиглэлээр өрийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, бүртгэл хөтлөх, тайлагнах механизмыг бүрдүүлэх;

Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 474 дүгээр тогтоолын хавсралтаар "Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын баталгаа гаргах журам"-ыг баталсан. Үүний хүрээнд Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн улсын төсөвт үзүүлэх дарамтыг тооцох, эрсдэлийг үнэлэх механизмыг гаргасан болно.

Түүнчлэн, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд төрөөс үзүүлэх дэмжлэг болох хөрөнгө оруулалт, эх үүсвэрийг улсын төсвөөс шийдвэрлэх, мөн төрөөс хариуцах газрын зөвшөөрөл, татварын хөнгөлөлт, худалдан авалт болон бусад асуудлыг тусгасан болно. Улсын төсөвт үзүүлэх

нөлөөлөл, эрсдэл тооцох загварыг Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан бөгөөд үүнийг Дэлхийн банкны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөвт үзүүлэх эрсдэлийн үнэлгээний загварыг ашиглаж боловсруулсан болно.

5.3 Засгийн газрын өрийн баталгаа гаргасан төслүүдийн эргэн төлөлт, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах;

Засгийн газрын өрийн баталгаа гаргасан байгууллагуудын жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд эрсдэлийн үнэлгээг хийж, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн Төрийн аудитын үйл ажиллагаагаар хянуулан ажиллаж байна.

Тухайлбал, 2023 оны 05 дугаар сард 2022 оны жилийн эцсийн байдлаар үлдэгдэлтэй Засгийн газрын өрийн баталгаа бүхий зээллэгийг авч ашигласан Монгол Улсын Хөгжлийн банк болон Эрдэнэс Монгол ХК-ийн хувьд эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэсэн бөгөөд тус байгууллагуудын хувьд эрсдэлийн үнэлгээ бага эрсдэлтэй гарсан болно.

Монгол Улсын Хөгжлийн банкны Япон Улсын санхүүгийн зах зээлд гаргасан “Самурай” бондын төлбөрийг банк нь өөрийн эх үүсвэрээс 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр бүрэн төлж барагдуулсан бол Эрдэнэс Монгол ХК-ийн Азийн Хөгжлийн банкнаас авч ашигласан Засгийн газрын өрийн баталгаат зээл нь 2031 онд төлөгдөх хуваарьтай бөгөөд хуваарийн дагуу төлж барагдуулж байна.

5.4 Төсвөөс шууд төлөгдөх нөхцөлтэй Барих-Шилжүүлэх төрлийн концессын гэрээ байгуулахгүй, өрийн бичиг /вексель/ шинээр гаргахгүй байх

Засгийн газраас шинээр Барих-Шилжүүлэх нөхцөлтэй концессын төрлийн гэрээ байгуулаагүй, мөн өрийн бичиг гаргаагүй болно. Барих-Шилжүүлэх нөхцөлтэй концессын гэрээний үлдэгдэл 2023 оны жилийн эцсээр 236.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бөгөөд Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн Засгийн газрын өрд бүртгэхгүй байхаар болсон.

Зорилт 6. Засгийн газрын өрийн удирдлагын ил тод байдлыг сайжруулна.

6.1 Улирал бүр Засгийн газрын өрийн товхимлыг олон нийтэд ил тод мэдээлэх

Засгийн газрын өрийн статистикийн товхимлыг улирал бүр бэлтгэн Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд олон нийтэд ил тод байдлаар улирал бүр байршуулж байна. Энэхүү мэдээлэл нь mof.gov.mn цахим хуудсанд байршиж байгаа бөгөөд Засгийн газрын өрийн статистикийн товхимолд Засгийн газрын өрийн үлдэгдэл, өрийн хугацааны ангилал, хүүгийн ангилал, зээлдүүлэгчдээр задалсан мэдээлэл, эргэн төлөлтийн мэдээлэл, төсөөлөл, гадаад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн мэдээллийг оруулдаг.

Түүнчлэн, хагас жил бүр санхүүгийн бус салбарын төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн өр төлбөрийг оруулсан улсын секторын өрийн статистикийг оруулдаг болно.

6.2 Улсын секторын өрийн мэдээллийг олон улсын байгууллагаас тогтоосон нэгдсэн стандартын дагуу бэлтгэж, мэдээлэх

Улсын секторын өрийн мэдээллийг Төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан 98 хуулийн этгээдүүдээс цуглуулж нэгтгэн хагас жил бүр Сангийн яамны цахим хуудсанд Олон улсын валютын сангийн стандартын дагуу нийтэд ил тод байдлаар тайлагнаж байна.

Түүнчлэн мэдээллийг нэгтгэсэн санг сайжруулах ажлыг зохион байгуулж E-balance санхүүгийн тайлангийн системд тогтсон загварыг үүсгэн байгууллагуудаас мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг боловсронгуй болгосон.